



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/594

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3./а/, б, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны Ээлжит IV хуралдааны 02, 2017 оны ээлжит V хуралдааны 5/03 дугаар тогтоол, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 52, 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өрхийн тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд Газар тариалангийн салбарын эрх зүйн бичиг баримтыг сурталчилан таниулах, сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, хөрс хамгаалах, сайжруулах, тариалангийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх талаарх сургалтанд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг хамруулж зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/-т үүрэг болгосугай.

3.Сурталчилан таниулах, сургалт зохион байгуулахад шаардагдах 4995000 /дөрвөн сая есөн зуун ерөн таван мянган/ төгрөгийг /Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтбөлбөр боловсруулан хэрэгжүүлэх/ зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэгт/-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



**ӨРХИЙН ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДЭД ГАЗАР
ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН БИЧИГ БАРИМТЫГ СУРТАЛЧИЛАН
ТАНИУЛАХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Ажил арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төг/	Нийт үнэ /мян.төг/	
1	“Газар тариалангийн салбарын эрх зүйн бичиг баримтын эмхэтгэл”-ын ном	400	9000	3600.0	
2	Бордооны зохистой хэрэглээ гарын авлага	300	1500	450.0	
3	Бордооны тун, норм тооцох аргачлал /жижиг/	300	500	150.0	
3	Тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, хөрс хамгаалах, сайжруулах, тариалангийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх талаарх сургалтыг зохион байгуулах.	Бичиг хэргийн зардал	200	1200	240.0
		Сургагч багш	2	80000	160.0
		Цайны завсарлага	200	1975	395.0
Нийт зардал		-	-	4995.0	